

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа ажиллуулах, төлбөрийн хэмжээг тогтоох тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолын төсөлд санал авч байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалтад аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь “Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах шийдвэр гаргах төлбөрийн хэм хэмжээг тогтоох”-оор заасны дагуу Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.5, 27.4.7 дэх заалтын хүрээнд иргэдээс санал авч байна.

Иймд иргэд та бүхэн тус журмын төсөлтэй танилцаж санал хүсэлтээ ирүүлэхийг хүсье.

Санал авах хугацаа: 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр дуусна.

Холбоо барих утас: 70523883, 88109583

Төсөлд тусгах саналаа Дорноговь цагдаа фэйсбүүк хаяг болон Oyunsuren@dornogovi.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Төсөл

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа ажиллуулах, төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалт, Хууль зүйн сайдын 2019 оны А/101 дүгээр тушаалаар батлагдсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйлдлийг таслан зогсоох, хөдөлгөөнд оролцогчдын хэвийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйл ажиллагааг **Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн хүрээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлсүгэй.**

2.Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх гудамж зам, хамрах хүрээ, үйлчлэх цагийн хязгаарыг нэгдүгээр хавсралтаар, тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа (байр) ажиллуулах үйл ажиллагааны төлбөрийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа байрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлага хангасан аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэн, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д үүрэг болгосугай.

4.Түр саатуулах хашаа (байр)-ны нийт талбайн хэмжээ 1000 м2-аас багагүй, зориулалтын чирэгч, ачигч автомашин тоо 3-аас доошгүй байхаар тогтоосугай.

5.Тогтоолыг хуулийн хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Батсугир)-д даалгасугай.

ДАРГА

Б.ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны дугаар сарын
-ны өдрийн дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ АЙМГИЙН ТӨВД ЗӨӨЖ ШИЛЖҮҮЛЭХ ГУДАМЖ ЗАМ, ХАМРАХ ХҮРЭЭ,
 ҮЙЛЧЛЭХ ЦАГ

Гудамж замын нэр	Хамрах хүрээ	Цаг
Сайншанд сумын 2 дугаар баг 4-н уулзвараас Эргэл зах хүртлэх замын	Зорчих хэсгийн талын урсгал	08.00-21.00 цагийн хооронд
Сайншанд сумын 2 дугаар баг 4-н уулзвараас Офицер хүртэлх замын	Зорчих хэсгийн 2 талын урсгал	08.00-21.00 цагийн хооронд
Сайншанд сумын 2 дугаар баг 4-н уулзвараас 75-н уулзвар хүртэлх зам	Автобусны зогсоол	06:00-22.00 цагийн хооронд
Сайншанд сумын 2 дугаар баг 4-н уулзвараас Нарлаг шандын уулзвар хүртэлх зам	Хойд 2 талын урсгал	08.00-21.00 цагийн хооронд
Оргилын уулзвараас урагшаа Морьтой хөшөө хүртэлх зам	Зорчих хэсгийн 2 талын урсгал	08.00-21.00 цагийн хооронд
Замын хөдөлгөөний дүрмээр зохицуулах тээврийн хэрэгсэл түр болон удаан зогсохыг хориглосон газруудад зогсоосон тохиолдолд	Замын хөдөлгөөний дүрмээр зохицуулагдах хориглосон газар	байнга

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны дугаар сарын
.....-ны өдрийн дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗӨӨЖ ШИЛЖҮҮЛЭХ, ТҮР СААТУУЛАХ ХАШАА/БАЙР/ АЖИЛЛУУЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

Нэг. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх

№	Зөөж шилжүүлэх хүрээ	Тоо	Төлбөрийн хэмжээ	Тайлбар
1	Аймгийн төвд 10 км дотор	1 удаа	55000 төгрөг	10 км-ээс дээш бол 1 км тутам 1300-1600 төгрөгөөр нэмж тооцох

Хоёр. Түр саатуулах хашаа /байр/-ны төлбөр

№	Автомашины төрөл	Нэг хоногт
1	Том оврын автомашин, механизм	7.500 төгрөг
2	Суудлын автомашин	5.000 төгрөг
3	Мотоцикль	3.000 төгрөг